



2014

ХҮҮХДИЙН ШУДАРГА БАЙДЛЫН СУДАЛГАА:

Хүүхдийн шударга байдлын
ТҮВШИН



UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Улаанбаатар 2014

АГУУЛГА

Хүснэгтийн жагсаалт	2
Зургийн жагсаалт	2
ДҮГНЭЛТ	3
ЗӨВЛӨМЖ	4
БҮЛЭГ 1. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, ТООЦООЛОЛ.....	5
1. СУДАЛГААНЫ ЗОРИЛГО	5
2. ХҮҮХДИЙН ШУДАРГА БАЙДЛЫН ТҮВШНИЙ ТООЦООЛОЛ	5
3. ТҮҮВРИЙН ДИЗАЙН	6
4. СУДАЛГААНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	6
БҮЛЭГ 2. ХҮҮХДИЙН ШУДАРГА БАЙДЛЫН СУДАЛГААНЫ ҮР ДҮН	8
1. СУДАЛГААНД ХАМРАГДСАН ХҮҮХДҮҮДИЙН БҮТЭЦ	8
2. ХҮҮХДИЙН ШУДАРГА БАЙДЛЫН ТҮВШИН	8
3. ХҮҮХДИЙН ШУДАРГА БАЙДЛЫН ТҮВШИН, ДЭД ҮЗҮҮЛЭЛТЭЭР.....	10
4. ХҮҮХДИЙН ШУДАРГА БАЙДАЛД НӨЛӨӨЛЖ БУЙ ХҮЧИН ЗҮЙЛС	10
5. ХҮҮХДҮҮДИЙН ОЙЛГОЛТ, ҮЗЭЛ БОДОЛ.....	15
ХАВСРАЛТ	21

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Хүүхдийн шударга байдлыг үнэлэхэд ашигласан асуулт	5
Хүснэгт 2. Хүүхдийн шударга байдлын дэд үзүүлэлтийг тооцсон асуулт, асуултын дугаараар	6
Хүснэгт 3. Судалгааны түүврийн хэмжээ аймаг, дүүргээр.....	6
Хүснэгт 4. Хүүхдийн шударга байдлын түвшин, дэд үзүүлэлтээр	10

Зургийн жагсаалт

Зураг 1. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн хүйс, анги, дүнд эзлэх хувиар	8
Зураг 2. Судалгаанд хамрагдсан хүүхдийн дүнд эзлэх хувь, аймаг, нийслэлээр	8
Зураг 3. Хүүхдийн шударга байдлын түвшин, оноор	9
Зураг 4. Хүүхдийн шударга байдлын түвшин, хүйсээр	10
Зураг 5. Хүүхдийн шударга байдлын түвшин, шударга байх талаар эцэг, эхтэйгээ ярилцдаг эсэх, хүйсээр	11
Зураг 6. Хүүхдийн шударга байдлын түвшин, шударга бус зүйлийн эсрэг эцэг, эхийн гаргаж буй үйлдлээр	12
Зураг 7. Хүүхдийн шударга байдлын түвшин, найз нь шударга бус үйлдэл хийхийг хүсдэг эсэх, хүйсээр.....	12
Зураг 8. Хүүхдийн шударга байдлын түвшин, шударга хандсаных нь төлөө сайшаагдаж байсан эсэхээр	13
Зураг 9. Хүүхдийн шударга байдлын түвшин, шударга ёсны талаар хичээл орох, эсхүл энэ талаар үйл ажиллагаа зохиогддог эсэхээр.....	14
Зураг 10. Шударга ёсны талаарх мэдээллийг хаанаас авдаг вэ?, хувиар	14
Зураг 11. Хүүхдийн шударга байдлын түвшин, хүүхдүүдийн мэдээлэл хүлээн авч буй эх үүсвэрээс хамаарч буй байдал.....	15
Зураг 12. “Баян байх”, эсхүл “шударга байх”-ын алийг нь илүүд үзэх вэ?.....	15
Зураг 13. Урт дараалалд зогсож байснаас урдуур нь дайрч кинонд орохыг хичээх үү?.....	16
Зураг 14. Гэрийн даалгавраа хийхдээ, интернет зэрэг бусдын бүтээлээс өөрөө хийсэн мэт авч ашиглах нь зөв үү?.....	16
Зураг 15. Багшдаа бэлэг өгөх нь дүнгээ ахиулах сайн арга гэдэгтэй санал нийлэх үү? ..	16
Зураг 16. Авлига болон бусад гэмт хэрэг үйлдсэн хүнийг холбогдох байгууллагад мэдэгдэх ёстой гэдэгтэй санал нийлэх үү?	17
Зураг 17. Таны сайн найз чинь шалгалт өгөхдөө бусдаас хуулах нь зөв үү?.....	17
Зураг 18. Багш хичээл зааж, сургууль төгсгөснийхөө төлөө сурагчдаас хариу шан харамж, бэлэг хүсэх нь зөв үү?.....	18
Зураг 19. Хууль сахиулагч хэн нэгэн таны дэргэд /ойр/ байхгүй үед хууль, дүрэм зөрчиж болох уу?.....	18
Зураг 20. Том хүмүүсийн хууль бус үйлдэл өөрт чинь ашигтай байвал буруу зүйл мөн үү?	18
Зураг 21. Шалгалтаа бусдаас хуулж байгаа хүн Таны сайн найз байсан ч багш, эцэг, эх, дотнын хүндээ мэдэгдэх үү?	19
Зураг 22. Танай гэр бүлийн хэн нэгэн албан тушаалаа ашиглах буюу хууль зөрчих замаар баян болох нь зөв үү?.....	19
Зураг 23. Шударга бус үйлдлийн талаар олон нийтэд мэдээлэх нь зөв үү?	20
Зураг 24. Багш нарын зүгээс шударга бус үйлдэл гаргаж, хүүхдүүдтэй зохисгүй харилцсан тохиолдолд хэнд хандах вэ?.....	20

Хүүхдийн шударга байдлын түвшин болон түүний дэд үзүүлэлт болох ёс зүй, ёс суртахуун, зөв төлөвшилт, хууль сахих болон авлигыг үл тэвчих байдал ямар түвшинд байгааг тодорхойлох, цаашид хүүхдүүдийг шударга иргэн болгон төлөвшүүлэхийн тулд авч хэрэгжүүлбэл зохих, шударга бус хандлагаас нь урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын чиглэлийг тогтоох зорилгоор 2014 оны “Хүүхдийн шударга байдлын судалгаа”-г Авлигатай тэмцэх газар, Хүүхдийн төлөө үндэсний газартай хамтран зохион байгууллаа. Энэ удаагийн судалгааны дүнд үндэслэн дараахь дүгнэлтийг хийж байна.

- Хүүхдийн шударга байдлын түвшин 2014 оны судалгаагаар 4.03¹ гэсэн дүнтэй гарсан нь 2010 оныхоос 0.74 пункт, 2012 оныхоос 1.10 пункт, 2013 оныхоос 0.32 пунктээр тус тус өссөн дүнтэй гарсан нь эерэг үзүүлэлт болж байна.
- Хүүхдийн шударга байдлын түвшин дэд үзүүлэлт болох ёс зүй, ёс суртахууны дэд үзүүлэлтийн дундаж үнэлгээ 4.07, зөв төлөвшилтийн дундаж үнэлгээ 4.32, хууль сахих байдлын дундаж үнэлгээ 4.04, авлигыг үл тэвчих байдлын дундаж үнэлгээ 3.68 байгаа нь өмнөх жилийнхээс 0.21-0.44 пунктээр нэмэгдсэн байна.
- Судалгааны дүнгээс харахад эмэгтэй хүүхдийн шударга байдлын түвшин эрэгтэй хүүхдийнхээс өндөр байна. 2014 оны байдлаар эмэгтэй хүүхдүүдийн шударга байдлын түвшин эрэгтэй хүүхдүүдийнхээс 0.10 пунктээр илүү байлаа.
- Эцэг, эх хүүхэдтэйгээ шударга байх талаар байнга ярилцаж байх нь тэднийг шударга хандлага гаргахад эерэгээр нөлөөлж байна. Эцэг, эхтэйгээ шударга байх талаар “байнга” ярилцдаг хүүхдүүдийн шударга байдлын түвшин ярилцаж чадахгүй байгаа хүүхдүүдийнхээс өндөр байна. Энэ нь 10 хүүхэд тутмын 3 нь шударга байх талаар эцэг эхтэйгээ маш цөөн удаа, эсхүл огт ярилцаж чадахгүй байна гэсэн үзүүлэлт юм.
- Хүүхдээ шударга бус зүйл хийхэд эцэг, эх ямар хариу үйлдэл үзүүлж байгаа нь тэдний зөв төлөвшилт, шударга байхад нөлөөлж байна. Өөрөөр хэлбэл, хүүхдээ буруу зүйл хийснийг мэдсэн эцэг, эх хүүхэддээ болохгүй зүйл хийснийг нь ойлгуулах, тайлбарлах шаардлагатай байна.
- Найз нөхдийн хүрээ тухайн хүүхдийн шударга байдлын түвшинд нөлөөлж байна. “Таны найз танаас шударга бус үйлдэл хийхийг хүсдэг үү?” гэсэн асуултад зөвхөн 55.2% нь л “огт үгүй” гэж хариулсан байна.
- Хүүхдийн шударга байдлын түвшинд эерэгээр нөлөөлж байгаа өөр нэг үзүүлэлт бол тухайн хүүхдийг шударга хандсаныг нь төлөө бусад хүмүүс тухайн хүүхдийг “магтах, сайшаах, урамшуулах” явдал болох нь харагдлаа.
- Хүүхдүүдэд шударга ёсны талаар хичээл орох, эсхүл энэ талаар үйл ажиллагаа зохиох нь тэдний шударга байдлын түвшинд эерэгээр нөлөөлж байгаа нь энэ удаагийн судалгааны дүнгээс харагдлаа. “Танай ангид ямар нэгэн байдлаар шударга ёсны талаар хичээл орох, эсхүл энэ төрлийн үйл ажиллагаа зохиогддог уу?” гэсэн асуултад “тийм” гэж хариулсан хүүхдүүдийн шударга байдлын түвшин “үгүй” гэж хариулсан хүүхдүүдийнхээс 0.16 пунктээр илүү байв.

¹ Хүүхдийн шударга байдлын түвшин болон дэд үзүүлэлтийг 1-5 хүртэлх оноогоор үнэлсэн бөгөөд уг үзүүлэлтийн утга 1-д ойртох тусам шударга бус, 5-д ойртох тусам шударга гэж ойлгоно.

- Хүүхдүүд шударга ёсны талаарх мэдээллийг гэр бүл, сургуулийн орчноос авах нь илүү үр дүнтэй байна. Шударга ёсны талаарх мэдээллийг “гэр бүл” болон “сургууль”-аас авдаг хүүхдүүд бусад эх үүсвэрээс мэдээлэл авдаг хүүхдүүдээс илүү шударга байна.

ЗӨВЛӨМЖ

БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГЫН ХУВЬД:

- Суралцагч (бага сургуулиас их, дээд сургууль хүртэлх)-ийн нэгдсэн ёс зүйн дүрмийг батлан, өмчийн бүх хэлбэрийн сургуулиудад мөрдүүлэх, хэрэгжилтэд нь хяналт тавих;
- Бүх шатны сургуулиудад шударга ёс (ёс зүй), авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх талаар хичээл оруулах, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөнд тусгах;
- Хүүхдүүдийн ил тод, шударга байдлыг нэмэгдүүлэх зорилгоор шударга үйл хийсэн хүүхдүүдийг шалгаруулан урамшуулах, шагнах зэрэг арга хэмжээг тогтмол зохион байгуулж, олон нийтэд мэдээлж байх.

ЭЦЭГ, ЭХ БОЛОН БУСАД ХҮМҮҮСИЙН ХУВЬД:

- Эцэг, эх болон бусад хүмүүсийн хувьд шударга байдлаараа гэр бүл, үр хүүхдүүддээ үлгэр жишээч байх;
- Хүүхдүүдийн гаргасан шударга бус үйлдлийг буруутгах, зэмлэл хүлээлгэх, эсхүл хайхрахгүй байхаас илүүтэй тэдэнд буруу зүйл хийснийг нь ойлгуулж, тайлбарлах. Хэрэв шударга үйл хийсэн бол тэднийг урамшуулж, сайшааж байх.

ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ХУВЬД:

- Хүүхдүүд шударга ёсны талаарх мэдээллийг телевиз, радио болон интернетээс авч байгаа бөгөөд ялангуяа, телевиз, радиогоор хүүхдийн шударга ёсыг дэмжсэн, сонирхол татахуйц хөтөлбөр, нэвтрүүлгийг бэлтгэн хүргэж байх;
- Телевизийн бусад нэвтрүүлгийн хувьд ил тод, шударга байдлыг дэмжсэн агуулга бүхий нэвтрүүлгийг түлхүү гаргах.

ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГЫН ХУВЬД:

- Ил тод байдал болон авлигатай тэмцэх үйл ажиллагаанд хөндлөнгөөс хяналт тавих үүрэг оролцоогоо нэмэгдүүлэх;
- Хүүхдийн ёс зүй, шударга байдлыг нэмэгдүүлэх талаар санал, санаачилга гаргах, энэ талаар холбогдох байгууллагуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлэх;
- Авлигын эсрэг боловсрол олгох болон шударга ёсны талаарх арга хэмжээг өргөнөөр зохион байгуулах.

БҮЛЭГ 1. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, ТООЦООЛОЛ

Хүүхдийн шударга байдлын судалгааг “Транспрэнси Интернэшнл Солонгос” байгууллагаас боловсруулсан арга зүйн дагуу анх 2008 онд Энэтхэг, Солонгос, Бангладеш, Монгол зэрэг оронд зохион байгуулж байсан билээ. Энэхүү арга зүйн дагуу манай улс Хүүхдийн шударга байдлын судалгааг 5 дахь удаагаа зохион байгуулаад байна.

1. СУДАЛГААНЫ ЗОРИЛГО

Монгол Улсын ирээдүй болсон хүүхдүүдийн шударга байдлын түвшин, түүний дэд үзүүлэлт болох ёс зүй, ёс суртахуун, зөв төлөвшилт, хууль сахих болон авлигыг үл тэвчих байдал ямар түвшинд байгааг тодорхойлох, цаашид хүүхдүүдийг шударга иргэн болгон төлөвшүүлэхийн тулд авч хэрэгжүүлбэл зохих урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын чиглэлийг тогтооход энэхүү судалгааны зорилго оршиж байна.

2. ХҮҮХДИЙН ШУДАРГА БАЙДЛЫН ТҮВШНИЙ ТООЦООЛОЛ

Хүүхдийн шударга байдлын судалгааны зорилгын нэг нь хүүхдийн шударга байдлын түвшнийг тодорхойлох бөгөөд судалгааны мэдээлэлд үндэслэн жил бүр хүүхдийн шударга байдлын түвшинг хэмжиж байгаа юм.

Хүүхдийн шударга байдлын түвшинг доорх 12 асуултад тухайн хүүхэд санал нийлж байгаа эсэхийг нь асууж, хариулт бүрийг 1-5 хүртэлх оноогоор үнэлж, үнэлгээний арифметик дунджаар хүүхдийн шударга байдлын түвшин болон дэд үзүүлэлтийг тооцсон болно. Хүүхдийн шударга байдлын түвшин 1-д ойртох тусам шударга бус, харин 5-д ойртох тусам шударга гэж үзнэ.

Хүснэгт 1. Хүүхдийн шударга байдлыг үнэлэхэд ашигласан асуулт

Асуултын дугаар	Асуулт
1.	Сайн найз чинь шалгалт өгөхдөө бусдаас хуулах нь буруу зүйл биш.
2.	Том хүмүүсийн хууль бус үйлдэл нь өөрт чинь ашигтай байвал буруу зүйл биш.
3.	Гэрийн даалгавраа хийхдээ интернет зэрэг бусдын бүтээлээс өөрөө хийсэн мэт ашиглах нь буруу зүйл биш.
4.	Ангийн дарга болохын тулд ангийнхандаа бэлэг өгөх нь буруу зүйл биш.
5.	Багшдаа бэлэг өгөх нь дүнгээ ахиулах сайн арга юм.
6.	Баян байх нь шударга байхаас илүү чухал.
7.	Багш хичээл зааж, сургууль төгсгөснийхөө төлөө сурагчдаас хариу шан харамж, бэлэг хүсэж болно.
8.	Шалгалтаа бусдаас хуулж байгаа хүн нь Таны сайн найз байсан ч багш, эцэг/эх/, дотнын хүндээ мэдэгдэнэ.
9.	Урт дараалалд зогсож байснаас урдуур нь дайрч кинондoo хурдан орохыг хичээнэ.
10.	Хууль сахиулагч хэн нэгэн таны дэргэд /ойр/ байхгүй үед хууль, дүрэм зөрчиж болно.
11.	Авлига болон бусад гэмт хэрэг үйлдсэн хүнийг холбогдох байгууллагад мэдэгдэнэ.
12.	Гэр бүлийнхэн чинь албан тушаалаа ашиглах буюу хууль зөрчих замаар баян болох нь буруу зүйл биш.

Хүүхдийн шударга байдлын түвшний дэд үзүүлэлт болох ёс зүй, ёс суртахуун, зөв төлөвшилт, хууль сахих болон авлигыг үл тэвчих байдлын үзүүлэлтийг тооцохдоо дээр дурдсан асуултуудын дагуу дэд үзүүлэлтийн дунджийг тооцсон болно. Дэд үзүүлэлт тооцоход ашигласан асуултыг дараахь хүснэгтээс харна уу.

Хүснэгт 2. Хүүхдийн шударга байдлын дэд үзүүлэлтийг тооцсон асуулт, асуултын дугаараар

	Ёс зүй, ёс суртахуун	Зөв төлөвшилт	Хууль сахих	Авлигыг үл тэвчих
Танин мэдэхүйн	3	4	1	2
Нөлөөллийн	6	5	7	8
Зан үйлийн	9	11	10	12

3. ТҮҮВРИЙН ДИЗАЙН

Судалгааны түүврийн хүрээ нь 2013-2014 онд Ерөнхий боловсролын сургуулийн 7-11 дүгээр ангид сурч буй хүүхдүүд байсан бөгөөд судалгаанд 7 аймаг, нийслэлийн 3 дүүрэг сонгогдсон юм.

Сонгогдсон аймаг, дүүргээс тусгайлан бэлтгэгдсэн асуулгын дагуу ярилцлагын аргаар, 802 хүүхдийг санамсаргүй байдлаар сонгон судалгаанд хамруулсан юм. Энэ удаагийн судалгаанд Хэнтий, Өмнөговь, Завхан, Дорнод, Дорноговь, Ховд, Орхон аймаг болон нийслэлийн Сонгинохайрхан, Сүхбаатар, Налайх дүүргийн хүүхдүүд хамрагдав.

Хүснэгт 3. Судалгааны түүврийн хэмжээ аймаг, дүүргээр

Д/д	Сонгогдсон аймаг, дүүргийн нэр	ЕБС-д суралцаж буй хүүхдийн тоо*, мян. хүүхэд	Түүврийн хэмжээ
1.	Дорноговь	11.1	52
2.	Дорнод	13.1	61
3.	Завхан	14.2	67
4.	Орхон	16.7	78
5.	Өмнөговь	10.4	49
6.	Ховд	17.9	85
7.	Хэнтий	13.3	62
8.	Налайх дүүрэг	5.6	28
9.	Сүхбаатар дүүрэг	31.1	146
10.	Сонгинохайрхан дүүрэг	37.2	174
	Дүн	159.5	802

*Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, 2014 он

4. СУДАЛГААНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Судалгааны мэдээлэл цуглуулах ажлыг Авлигатай тэмцэх газрын Судалгаа шинжилгээний алба, Хүүхдийн төлөө үндэсний газартай хамтран сонгогдсон

аймаг, дүүрэгт зохион байгууллаа. Сонгогдсон аймаг, дүүргээс мэдээллийг цуглуулах ажлыг 2014 оны 04 дүгээр сарын 05-30-ны хооронд зохион байгуулж, судалгааны мэдээллийг 2014 оны 6 дугаар сарын 10-20-ны хооронд компьютерт шивж оруулсан юм.


UIH.MN
СУДАЛГААНЫ САН

БҮЛЭГ 2. ХҮҮХДИЙН ШУДАРГА БАЙДЛЫН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

1. СУДАЛГААНД ХАМРАГДСАН ХҮҮХДҮҮДИЙН БҮТЭЦ

Хүүхдийн шударга байдлын 2014 судалгаанд хамрагдсан 802 хүүхдийн 48.8% нь эрэгтэй, 51.2% нь эмэгтэй байлаа (Зураг 1).


Зураг 1. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн хүйс, анги, дүнд эзлэх хувиар



Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийг суралцаж буй ангиар нь авч үзвэл 7 дугаар ангийн сурагч 10.3%, 8 дугаар ангийн сурагч 17.6%, 9 дүгээр ангийн сурагч 22.8%, 10 дугаар ангийн сурагч 26.5%, 11 дүгээр ангийн сурагч 22.8% нь байлаа.

Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийг аймаг, нийслэлээр авч үзвэл 56.6% нь нийслэл Улаанбаатар хотоос, 43.4% нь аймгаас хамрагдсан байна.

Зураг 2. Судалгаанд хамрагдсан хүүхдийн дүнд эзлэх хувь, аймаг, нийслэлээр




2. ХҮҮХДИЙН ШУДАРГА БАЙДЛЫН ТҮВШИН

Хүүхдийн шударга байдлын судалгааны мэдээлэлд үндэслэн Хүүхдийн шударга байдлын түвшинг 4 дэд үзүүлэлт (түвшинг ёс зүй, ёс суртахуун, зөв төлөвшилт, хууль сахиу, авлигыг үл тэвчих)-ийн хамт тооцдог. Хүүхдийн шударга байдлын түвшин болон дэд үзүүлэлтийг 1-5 хүртэлх оноогоор үнэлсэн бөгөөд уг

үзүүлэлтийн утга 1-д ойртох тусам шударга бус, 5-д ойртох тусам шударга гэж ойлгоно (үнэлгээний талаар дэлгэрэнгүйг хавсралтаас харна уу).


Хүүхдийн шударга байдлын түвшин 2014 оны судалгаагаар 4.03 гэсэн дүнтэй гарлаа. Энэ нь 2010 оныхоос 0.74 пункт, 2012 оныхоос 1.10 пункт, 2013 оныхоос 0.32 пунктээр тус тус өссөн дүн бөгөөд шударга байдлын түвшин нэмэгдсэн байгааг илэрхийлж байна.

Зураг 3. Хүүхдийн шударга байдлын түвшин², оноор



Хүүхдүүдийн шударга байдлыг мөн суралцаж буй ангиар нь авч үзвэл 7 болон 8 дугаар ангийн хүүхдийн шударга байдлын түвшин тус бүр 4.11 гэсэн үнэлгээтэй гарсан нь хамгийн өндөр үзүүлэлт болж байгаа бол шударга байдлын түвшин доогуур нь 10 болон 11 дүгээр ангийн хүүхэд байна.

Зураг 5. Хүүхдийн шударга байдлын түвшин, суралцаж буй ангиар




Хүүхдийн шударга байдлын түвшин мөн хүйсийн хувьд зөрүүтэй байгаа юм. Сүүлийн 2 удаагийн судалгааны дүнгээс харахад эмэгтэй хүүхдийн шударга байдлын түвшин эрэгтэй хүүхдийнхээс өндөр байна. Тухайлбал, 2014 оны

² Хүүхдийн шударга байдлын түвшин 1-д ойртох тусам шударга бус, харин 5-д ойртох тусам шударга гэж үзнэ.

байдлаар эмэгтэй хүүхдүүдийн шударга байдлын түвшин эрэгтэй хүүхдүүдийнхээс 0.10 пунктээр өндөр байна.

Зураг 4. Хүүхдийн шударга байдлын түвшин, хүйсээр



3. ХҮҮХДИЙН ШУДАРГА БАЙДЛЫН ТҮВШИН, ДЭД ҮЗҮҮЛЭЛТЭЭР

Хүүхдийн шударга байдлын түвшинг ёс зүй, ёс суртахуун, зөв төлөвшилт, хууль сахих, авлигыг үл тэвчих гэсэн 4 бүлэг дэд үзүүлэлт тус бүрийн хүрээнд үнэлгээг авч үзэв. Ёс зүй, ёс суртахууны дундаж үнэлгээ нь 4.07, зөв төлөвшилтийн дундаж үнэлгээ нь 4.32, хууль сахих байдлын дундаж 4.04, авлигыг үл тэвчих байдлын дундаж үнэлгээ 3.68 байгаа нь өмнөх жилийнхтэй харьцуулахад эдгээр үзүүлэлт 0.21-0.44 пунктээр нэмэгдсэн эерэг дүнтэй байна. Хүүхдийн шударга байдлын түвшний үнэлгээ болон дэд үзүүлэлт болон тооцооллын дэлгэрэнгүйг хавсралтаас харна уу.

Хүснэгт 4. Хүүхдийн шударга байдлын түвшин, дэд үзүүлэлтээр

	2010	2012	2013	2014
ХҮҮХДИЙН ШУДАРГА БАЙДЛЫН ТҮВШИН	3.29	2.93	3.71	4.03
Ёс зүй, ёс суртахуун	3.03	2.73	3.80	4.07
Зөв төлөвшилт	2.51	2.29	3.88	4.32
Хууль сахих	3.54	2.85	3.83	4.04
Авлигыг үл тэвчих	2.98	2.81	3.35	3.68


4. ХҮҮХДИЙН ШУДАРГА БАЙДАЛД НӨЛӨӨЛЖ БҮЙ ХҮЧИН ЗҮЙЛС

Хүүхдийн ёс зүй, ёс суртахуун, зөв төлөвшилт, хууль, дүрэм журмыг дээдлэх болон авлигыг үл тэвчих байдал нь тэднийг тойрон хүрээлж буй эцэг, эх, найз нөхдийн орчин, сургууль болон мэдээллийг хүлээн авч байгаа сувгаас ихээхэн хамаарч байдаг. Энэ удаагийн судалгаагаар хүүхдийн шударга байдлын түвшин эдгээр хүчин зүйлс (хүүхдийн эцэг, эх, найз, нөхөд, сургууль, мэдээлэл хүлээн авч бус суваг)-ээс хэрхэн хамаарч байгаад шинжилгээ хийсэн юм.

Эцэг, эх:

Энэ удаагийн судалгаагаар хүүхдүүд шударга байх эсэхэд ямар шалтгаан, хүчин зүйл нөлөөлж байгааг тодорхойлохыг зорьсон юм. Энэ хүрээнд хүүхдүүдийн шударга байдалд нөлөөлөгч нэг хүчин зүйл болох эцэг, эхийн нөлөөллийг авч үзлээ. Судалгааны асуулгын дагуу “Шударга байх талаар эцэг, эх тань тантай ярилцдаг уу?” гэсэн асуултыг хүүхдүүдээс асуусан бөгөөд хүүхдүүдийн 27.6% нь “байнга”, 46.1% нь “заримдаа”, 21.2% нь “маш цөөн удаа”, 5.1% нь огт ярилцдаггүй гэж хариулсан байна. Эндээс харахад дунджаар 10 хүүхэд тутмын 3 нь шударга байх талаар эцэг эхтэйгээ маш цөөн удаа, эсхүл огт ярилцдаггүй байна. Хүүхдүүдтэй ийнхүү эцэг, эхтэйгээ шударга байх талаар ярилцах нь тэдний шударга байдалд хэрхэн нөлөөлж байгааг энэ удаагийн судалгаа харууллаа. “Байнга” ярилцдаг гэж хариулсан хүүхдүүдийн шударга байдлын түвшин бусад хүүхэд буюу “заримдаа ярилцдаг”, “маш цөөн удаа ярилцдаг” болон “огт ярилцдаггүй” гэж хариулсан хүүхдүүдийнхээс өндөр байгааг доорх зургаар харуулав.

Зураг 5. Хүүхдийн шударга байдлын түвшин, шударга байх талаар эцэг, эхтэйгээ ярилцдаг эсэх, хүйсээр



Эмэгтэй хүүхдүүд эрэгтэй хүүхдүүдээс илүүтэй шударга хандлагатай байна. Эцэг, эх хүүхэдтэйгээ шударга байх талаар байнга ярилцаж байх нь тэднийг шударга хандлага гаргахад эерэгээр нөлөөлж байна.

Үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх нь иргэн бүрийн журамт үүрэг билээ. Судалгаагаар “Таныг шударга бус зүйл хийснийг эцэг, эх тань мэдвэл яадаг вэ?” гэж хүүхдүүдээс асуусан бөгөөд хүүхдүүдийн 72.2% нь “болохгүй зүйл хийснийг минь хэлж ойлгуулдаг” гэж хариулсан бол 27.8% нь “ямар ч үйлдэл хийдэггүй”, “сонирхдоггүй”, “зэмлэл хүлээлгэж шийтгэдэг” гэж хариулсан байна. Хүүхдээ шударга бус зүйл хийхэд эцэг, эх ямар хариу үйлдэл үзүүлж байгаа нь тэдний зөв төлөвшилт, шударга байх хандлагад нь хэрхэн нөлөөлж байгааг доорх зургаар харуулав.

“Болохгүй зүйл хийснийг минь хэлж ойлгуулдаг” гэж хариулсан хүүхдүүдийн шударга байдлын түвшин 4.05 байгаа нь “ямар ч үйлдэл хийдэггүй” гэж хариулсан хүүхдийнхээс 0.34 пунктээр илүү байна.


Зураг 6. Хүүхдийн шударга байдлын түвшин, шударга бус зүйлийн эсрэг эцэг, эхийн гаргаж буй үйлдлээр



Найз, нөхөд бусад хүмүүс:

Хүүхдүүдийн хувьд шударга байх, эсхүл зөв төлөвшилт олж авахад эцэг, эхээс гадна найз, нөхдийн хүрээ нөлөөтэй байдаг. Энэ удаагийн судалгаагаар хүүхдүүдээс “Таны найз танаас шударга бус үйлдэл хийхийг хүсдэг үү?” гэж асуусан бөгөөд судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 2.6% нь “байнга”, 11.6% нь “заримдаа”, 30.5% нь “маш цөөн удаа”, 55.2% нь “огт үгүй” гэж хариулсан байна. Эндээс харахад хүүхдүүдийн найз нөхдийн дунд шударга бус үйлдэл хийхийг хүсэх байдал бага бус байгааг харьж болох юм. Хүүхдүүдийн найз нөхдийн нөлөөлөл тэднийг шударга байхтай ямар хамааралтай байгааг доорх зургаар харуулав.

Зураг 7. Хүүхдийн шударга байдлын түвшин, найз нь шударга бус үйлдэл хийхийг хүсдэг эсэх, хүйсээр




Мөн л ямар нэгэн байдлаар найз нар нь “шударга бус үйлдэл” хийхийг хүсдэггүй хүүхдүүдийн шударга байдлын түвшин ямар нэгэн байдлаар хүсдэг буюу

“байнга”, “заримдаа”, “маш цөөн удаа” гэж хариулсан хүүхдүүдийнхээс өндөр байна.

Хүүхдийн шударга байдлын түвшинд нөлөөлж байгаа өөр нэг үзүүлэлт бол тухайн хүүхдийг шударга хандсаных нь төлөө хүмүүс “магтах, сайшаах, урамшуулах” явдал юм. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдээс “Шударга хандсаныхаа төлөө сайшаагдаж байсан уу?” гэж асуухад тэдний 69.7% нь “тийм”, 16.3% нь “зарим нь сайшаадаг ч, зарим нь үгүй”, 14.0% нь “үгүй” гэж хариулжээ.

Зураг 8. Хүүхдийн шударга байдлын түвшин, шударга хандсаных нь төлөө сайшаагдаж байсан эсэхээр



Эндээс харахад хүүхдүүд шударга хандсаныхаа төлөө сайшаагдаж байсан буюу “тийм” гэж хариулсан хүүхдүүдэд хамаарах шударга байдлын түвшин 4.06 буюу хамгийн өндөр байгаа бол “зарим нь сайшаадаг ч, зарим нь үгүй” гэж хариулсан хүүхдийнх 4.00, “сайшаагдаж байгаагүй буюу үгүй” гэж хариулсан хүүхдүүдийн 3.89 болж буурчээ.


Сүргүүл:

Ёс зүй, ёс суртахуун, зөв төлөвшилтийн болон авлигыг үл тэвчих үзлийг хүүхдүүдэд бага наснаас нь эхлэн төлөвшүүлэх, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөнд тусгах шаардлагатай байгаа зэргийг Хүүхдийн шударга байдлын судалгааны өмнөх жилийн тайлангуудын зөвлөмжид тусгасан байдаг.

Энэ удаагийн судалгаагаар хүүхдүүдээс “Танай ангид ямар нэгэн байдлаар шударга ёсны талаар хичээл орох, эсхүл энэ төрлийн үйл ажиллагаа зохиогддог уу?” гэж асуусан бөгөөд хүүхдүүдийн 77.3% нь “тийм”, 22.7% нь “үгүй” гэж хариулсан байна.

Хүүхдүүдэд шударга ёсны талаар хичээл орох, эсхүл шударга ёсны талаар ямар нэгэн үйл ажиллагаа зохиогдож байх нь тэдний шударга байдлын түвшинд нөлөөлж байгаа нь судалгаанаас харагдаж байна. “Танай ангид ямар нэгэн байдлаар шударга ёсны талаар хичээл орох, эсхүл энэ төрлийн үйл ажиллагаа зохиогддог уу?” гэсэн асуултад “тийм” гэж хариулсан хүүхдүүдийн шударга байдлын түвшин “үгүй” гэж хариулсан хүүхдүүдийнхээс 0.16 пунктээр илүү байгааг доорх зургаар харуулав.

Зураг 9. Хүүхдийн шударга байдлын түвшин, шударга ёсны талаар хичээл орох, эсхүл энэ талаар үйл ажиллагаа зохиогддог эсэхээр




Хүүхдүүдэд ямар нэгэн байдлаар шударга ёсны талаар хичээл орох нь тэдний шударга байдлын түвшинг нэмэгдүүлэхэд эерэг нөлөө үзүүлэх боломжтой байгааг энэ удаагийн судалгааны дүн дахин харууллаа.

Мэдээллийн орчин:


Судалгааны дүнгээс харахад хүүхдүүдийн ихэнх хэсэг нь шударга ёсны талаарх мэдээллийг сургууль (27.1-27.2%), гэр бүл (20.6-22.4%), телевиз, радио (12.8-17.4%)-гоос хүлээн авч байна. Хэдий тийм ч, цөөнгүй тооны хүүхэд найз нөхөд, интернет болон бусад эх үүсвэрээс мэдээлэл хүлээн авч байна.

Зураг 10. Шударга ёсны талаарх мэдээллийг хаанаас авдаг вэ?, хувиар



Хүүхдүүд шударга ёсны талаарх мэдээллийг гэр бүл, сургуулийн орчноос авах нь илүү үр дүнтэй байна. Шударга ёсны талаарх мэдээллийг “гэр бүл” болон “сургууль”-аас авдаг хүүхдүүд бусад эх үүсвэрээс мэдээлэл авдаг хүүхдүүдээс илүү шударга байгааг мөн судалгаа харууллаа.

Зураг 11. Хүүхдийн шударга байдлын түвшин, хүүхдүүдийн мэдээлэл хүлээн авч буй эх үүсвэрээс хамаарч буй байдал




Тухайлбал, гэр бүл, сургуулиасаа шударга ёсны талаар мэдээлэл авдаг хүүхдийн шударга байдлын түвшин хамгийн өндөр буюу 4.09-4.10 байгаа бол сонин хэвлэл, найз нөхөд, интернетээс мэдээлэл авдаг гэж хариулсан хүүхдүүдийн шударга байдлын түвшин доогуур буюу 3.84-3.88 гэсэн үзүүлэлттэй гарчээ.

5. ХҮҮХДҮҮДИЙН ОЙЛГОЛТ, ҮЗЭЛ БОДОЛ

Хүүхдийн шударга байдлын түвшинг тооцоход ашигласан үндсэн 12 асуултын хүрээнд хүүхдийн ойлголт, үзэл бодлыг тодорхой харуулахын тулд сүүлийн хоёр удаагийн судалгааны дүнг харьцуулсан байдлаар энэ хэсэгт авч үзлээ.


Судалгаагаар “баян байх”, эсхүл “шударга байх”-ын алийг нь хүүхдүүд илүүд үзэж байгааг тодорхойлохыг зорьсон юм. 2014 оны байдлаар хүүхдүүдийн 80.7% нь “шударга байх”-ыг илүүд үзэж байгаа ч 6.9% нь “баян байх”-ыг илүүд үзсэн бол мөн 12.5% нь “мэдэхгүй” хариулт өгсөн байна.

Зураг 12. “Баян байх”, эсхүл “шударга байх”-ын алийг нь илүүд үзэх вэ?




Судалгаанд хамрагдсан хүүхдүүдээс “урт дараалалд зогсож байснаас урдуур нь дайрч кинондоо хурдан орохыг хичээх” эсэхийг асуусан юм. Сүүлийн хоёр удаагийн судалгаагаар хүүхдүүдийн 68.5-72.9% нь урдуур нь дайрахгүй гэж хариулсан бол үлдсэн хэсэг болох 27.1-31.5% нь буюу 10 хүүхэд тутмын 3 нь урдуур нь дайрах, эсхүл ямар үйлдэл гаргахаа мэдэхгүй байгаагаа илэрхийлсэн байна.

Зураг 13. Урт дараалалд зогсож байснаас урдуур нь дайрч кинонд хурдан орохыг хичээх үү?




“Хүүхдүүд гэрийн даалгавраа хийхдээ, интернет зэрэг бусдын бүтээлээс өөрөө хийсэн мэт авч ашиглах нь зөв” эсэхийг тодруулсан. Сүүлийн 2 удаагийн судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 63.1-70.6% нь “буруу” хэмээн үзсэн бол 29.4-36.9% нь “зөв”, эсхүл “мэдэхгүй” гэж хариулсан байна

Зураг 14. Гэрийн даалгавраа хийхдээ, интернет зэрэг бусдын бүтээлээс өөрөө хийсэн мэт авч ашиглах нь зөв үү?



Хүүхдүүдийн үзэл бодлыг тодорхойлохын тулд “ямар нэгэн байдлаар багшдаа бэлэг өгөх нь дүнгээ ахиулах сайн арга” гэдэгтэй санал нийлж байгаа эсэхийг нь тодруулсан юм. Хүүхдүүдийн дийлэнх хэсэг буюу 74.6-87.5% нь энэ аргатай санал нийлэхгүй гэж хариулсан байгаа ч мөн “санал нийлж байгаа”, “мэдэхгүй” гэж хариулсан хүүхэд 12.5% буюу ойролцоогоор 10 хүүхэд тутмын 1 нь энэ аргыг хүлээн зөвшөөрсөн хариулт өгчээ.


Зураг 15. Багшдаа бэлэг өгөх нь дүнгээ ахиулах сайн арга гэдэгтэй санал нийлэх үү?



“Авлига болон бусад гэмт хэрэг үйлдсэн хүнийг холбогдох байгууллагад мэдэгдэх ёстой” гэдэгтэй хүүхдүүдийн 77.3% нь санал нийлж байгаа бол 7.9% нь


мэдэхгүй, 14.8% нь санал нийлэхгүй гэж хариулсан байна. “Авлига болон бусад гэмт хэрэг үйлдсэн хүнийг холбогдох байгууллагад мэдэгдэх ёстой” гэж үзэж байгаа хүүхдийн хувийн жин өмнөх судалгааныхаас 15.4 пунктээр нэмэгдсэн байна.

Зураг 16. Авлига болон бусад гэмт хэрэг үйлдсэн хүнийг холбогдох байгууллагад мэдэгдэх ёстой гэдэгтэй санал нийлэх үү?




Судалгаанд хамрагдсан 7-11 дүгээр ангийн хүүхдүүдийн үзэж байгаагаар сайн найз нь шалгалт өгөхдөө бусдаас хуулах нь “буруу” гэдэгтэй 52.5% нь санал нийлж байгаа бол үлдсэн хэсэг болох 47.5% буюу дунджаар 2 хүүхэд тутмын 1 нь “зөв”, эсхүл “мэдэхгүй” гэж хариулсан байгаа нь өндөр дүн болж байна.

Зураг 17. Таны сайн найз чинь шалгалт өгөхдөө бусдаас хуулах нь зөв үү?



Багш нар хүүхдүүдээс ямар нэгэн байдлаар бэлэг авах явдал нь буруу гэж хүүхдүүд үзэж байна. Сүүлийн 2 удаагийн судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 73.3-74.3% нь багш хичээл зааж, сургууль төгсгөснийхөө төлөө сурагчдаас хариу шан харамж, бэлэг хүсэх нь буруу гэж үзэж байна. Багшдаа бэлэг өгөхийг буруу гэж үзэж байгаа хүүхдүүд нэлээд байгаа ч хүүхдүүдийн 25.8-26.7% нь “мэдэхгүй”, эсхүл “зөв” гэж үзсээр байгааг анхаарах шаардлагатай байна.


Зураг 18. Багш хичээл зааж, сургууль төгсгөснийхөө төлөө сурагчдаас хариу шан харамж, бэлэг хүсэх нь зөв үү?



Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 85.9% нь хууль сахиулагч хэн нэгэн дэргэд /ойр/ байхгүй үед ч хууль зөрчих нь буруу гэж хариулсан нь өмнөх оны дүнгээс 19.5 пунктээр нэмэгдсэн эерэг үзүүлэлт болж байна.


Мөн 2014 оны судалгаагаар хүүхдүүдийн 4.7% нь хууль сахиулагч хэн нэгэн дэргэд байхгүй үед хууль зөрчих нь “зөв”, 9.4% нь “мэдэхгүй” гэсэн хариултыг өсөн байна.

Зураг 19. Хууль сахиулагч хэн нэгэн таны дэргэд /ойр/ байхгүй үед хууль, дүрэм зөрчиж болох уу?



“Том хүмүүсийн хууль бус үйлдэл өөрт чинь ашигтай байвал буруу зүйл мөн үү?” гэсэн асуултад судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 74.2% нь “тийм”, 7.2% нь “үгүй” гэж хариулсан байна. Гэвч энэ байдалд эргэлзсэн буюу мэдэхгүй гэж 18.6% нь хариулсан байна.


Зураг 20. Том хүмүүсийн хууль бус үйлдэл өөрт чинь ашигтай байвал буруу зүйл мөн үү?



Хүүхдүүдийн хувьд шударга байдлын талаарх төсөөллийг үнэлэхэд ашигласан өөр нэг асуулт бол “Шалгалтаа бусдаас хуулж байгаа хүн Таны сайн найз байсан ч багш, эцэг, эх, дотнын хүндээ мэдэгдэх үү?” гэсэн асуулт байв.


Сүүлийн 2 удаагийн судалгааны дүнгээр дээрх асуултад хүүхдүүдийн 39.5-44.8% нь “үгүй”, 22.4-28.0% нь “тийм” гэсэн хариулт өгсөн байна. Улаанбаатар хотын Сүхбаатар дүүргээс судалгаанд хамрагдсан 13 настай нэгэн хүүхэд “хүүхдүүд аав, ээждээ зэмлүүлэхгүй, эсхүл дүнгээ ахиулахын тулд шалгалтаа хуулдаг” гэж ярьсан юм. Үнэхээр эцэг, эх хүүхдээ зэмлэх, зарим зүйлийг шаардах зэрэг нь тухайн хүүхдийг шалгалтаа хуулах, эсхүл хууль бус үйлдэл гаргахад нь нөлөөлж байж болох юм.

Зураг 21. Шалгалтаа бусдаас хуулж байгаа хүн Таны сайн найз байсан ч багш, эцэг, эх, дотнын хүндээ мэдэгдэх үү?




“Танай гэр бүлийн хэн нэгэн албан тушаалаа ашиглах буюу хууль зөрчих замаар баян болох нь зөв үү?” гэсэн асуултад хүүхдүүдийн 77.8% нь “буруу” гэж хариулсан бол 6.1% нь “зөв”, 16.1% нь мэдэхгүй гэж хариулсан байна.

Зураг 22. Танай гэр бүлийн хэн нэгэн албан тушаалаа ашиглах буюу хууль зөрчих замаар баян болох нь зөв үү?




Аливаа шударга бус үйлдлийг үл тэвчих байдлыг тодорхойлох зорилгоор хүүхдүүдээс шударга бус үйлдлийн талаар олон нийтэд мэдээлж байх нь зөв эсэхийг тэднээс асуусан юм. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 79.8-81.0% нь шударга бус үйлдлийн талаар олон нийтэд мэдээлэх нь зөв гэж үзэж байгаа бол 19.0-20.2% нь буруу гэж үзсэн байна.

Зураг 23. Шударга бус үйлдлийн талаар олон нийтэд мэдээлэх нь зөв үү?



Багш нарын зүгээс шударга бус үйлдэл гаргаж, хүүхдүүдтэй зохисгүй харилцсан тохиолдолд хэнд хандахыг нь тодруулсан юм. Судалгаагаар эрэгтэй хүүхдүүдийн 24.7% нь сургуулийн захиргаанд, 23.5% нь эцэг эхдээ, 18.7% нь ангийн багцдаа хандана гэж хариулсан бол эмэгтэй хүүхдүүдийн 30.7% нь эцэг, эхдээ, 20.0% нь сургуулийн захиргаанд, 18.1% нь ангийн багцдаа хандана гэсэн үзүүлэлттэй байна. Үүнээс гадна, судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн хамгийн бага хувь буюу 2.1-2.5% нь хүүхдийн утас “1979”-д хандана гэсэн байгаа нь хүүхдүүд энэ утасны талаар мэдээлэл муутай байдагтай холбоотой байж болох юм.

Зураг 24. Багш нарын зүгээс шударга бус үйлдэл гаргаж, хүүхдүүдтэй зохисгүй харилцсан тохиолдолд хэнд хандах вэ?



---oOo---

ХАВСРАЛТ

Хавсралт 1. Хүүхдийн шударга байдлын түвшин дэд үзүүлэлтээр³

Д/д		Үзүүлэлт	Үнэлгээ			
			2010	2012	2013	2014
ХҮҮХДИЙН ШУДАРГА БАЙДЛЫН ТҮВШИН			3.29	2.93	3.71	4.03
А. Ес зүй, ёс суртахууны дэд үзүүлэлт			3.03	2.73	3.80	4.07
	Танин мэдэхүйн	Гэрийн даалгавраа хийхдээ интернет зэрэг бусдын бүтээлээс өөрөө хийсэн мэт ашиглах нь буруу зүйл биш.	3.20	2.72	3.66	3.94
	Нөлөөллийн	Баян байх нь шударга байхаас илүү чухал.	2.70	2.49	3.91	4.28
	Зан үйлийн	Урт дараалалд зогсож байснаас урдуур нь дайрч кинондоо хурдан орохыг хичээнэ.	3.20	2.99	3.82	3.99
Б. Зөв төлөвшилтийн дэд үзүүлэлт			2.51	2.29	3.88	4.32
	Танин мэдэхүй	Ангийн дарга болохын тулд ангийнхандаа бэлэг өгөх нь буруу зүйл биш.	2.20	1.85	3.99	4.45
	Нөлөөллийн	Багшдаа бэлэг өгөх нь дүнгээ ахиулах сайн арга юм.	2.20	1.94	4.08	4.48
	Зан үйлийн	Авлига болон бусад гэмт хэрэг үйлдсэн хүнийг холбогдох байгууллагад мэдэгдэнэ.	3.10	3.10	3.57	4.02
В. Хууль сахиу байдлын дэд үзүүлэлт			3.54	2.85	3.83	4.04
	Танин мэдэхүй	Сайн найз чинь шалгалт өгөхдөө бусдаас хуулах нь буруу зүйл биш.	4.42	3.61	3.63	3.63
	Нөлөөллийн	Багш хичээл зааж, сургууль төгсгөснийхөө төлөө сурагчдаас хариу шан харамж, бэлэг хүсэж болно.	3.40	2.96	4.02	4.10
	Зан үйлийн	Хууль сахиулагч хэн нэгэн таны дэргэд /ойр/ байхгүй үед хууль, дүрэм зөрчиж болно.	2.80	1.98	3.83	4.38
Г. Авлигыг үл тэвчих байдлын дэд үзүүлэлт			2.98	2.81	3.35	3.68
	Танин мэдэхүйн	Том хүмүүсийн хууль бус үйлдэл нь өөрт чинь ашигтай байвал буруу зүйл биш.	2.70	2.34	3.69	4.15
	Нөлөөллийн	Шалгалтаа бусдаас хуулж байгаа хүн нь Таны сайн найз байсан ч багш, эцэг/эх/, дотнын хүндээ мэдэгдэнэ.	3.35	3.11	2.73	3.29
	Зан үйлийн	Гэр бүлийнхэн чинь албан тушаалаа ашиглах буюу хууль зөрчих замаар баян болох нь буруу зүйл биш.	2.90	2.97	3.65	4.19

³ Хүүхдийн шударга байдлын түвшин 1-д ойртох тусам шударга бус, харин 5-д ойртох тусам шударга гэж үзнэ.

Хавсралт 2. 2014 оны судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн асуултад хариулсан байдал, дүнд эзлэх хувиар

Асуулт	Санал огт нийлэхгүй	Санал нийлэхгүй	Эргэлзэж байна/ мэдэхгүй	Санал нийлж байна	Санал бүрэн нийлж байна	ДҮН
Сайн найз чинь шалгалт өгөхдөө бусдаас хуулах нь буруу зүйл биш.	29.1%	23.4%	32.0%	12.7%	2.7%	100.0%
Том хүмүүсийн хууль бус үйлдэл нь өөрт чинь ашигтай байвал буруу зүйл биш.	51.4%	22.8%	18.6%	4.2%	3.0%	100.0%
Гэрийн даалгавраа хийхдээ интернет зэрэг бусдын бүтээлээс өөрөө хийсэн мэт ашиглах нь буруу зүйл биш.	43.5%	27.1%	13.7%	11.0%	4.7%	100.0%
Ангийн дарга болохын тулд ангийнхандаа бэлэг өгөх нь буруу зүйл биш.	66.1%	22.1%	5.9%	3.1%	2.9%	100.0%
Багшдаа бэлэг өгөх нь дүнгээ ахиулах сайн арга юм.	66.7%	20.8%	7.9%	2.9%	1.7%	100.0%
Баян байх нь шударга байхаас илүү чухал.	58.4%	22.3%	12.5%	2.9%	4.0%	100.0%
Багш хичээл зааж, сургууль төгсгөснийхөө төлөө сурагчдаас хариу шан харамж, бэлэг хүсэж болно.	49.4%	23.9%	16.0%	8.9%	1.9%	100.0%
Шалгалтаа бусдаас хуулж байгаа хүн нь Таны сайн найз байсан ч багш, эцэг/эх/, дотнын хүндээ мэдэгдэнэ.	20.1%	19.5%	38.0%	14.6%	7.9%	100.0%
Урт дараалалд зогсож байснаас урдуур нь дайрч кинондоо хурдан орохыг хичээнэ.	39.7%	33.3%	15.7%	9.0%	2.4%	100.0%
Хууль сахиулагч хэн нэгэн таны дэргэд /ойр/ байхгүй үед хууль, дүрэм зөрчиж болно.	57.6%	28.3%	9.4%	3.6%	1.1%	100.0%
Авлига болон бусад гэмт хэрэг үйлдсэн хүнийг холбогдох байгууллагад мэдэгдэнэ.	9.0%	5.9%	7.9%	28.6%	48.8%	100.0%
Гэр бүлийнхэн чинь албан тушаалаа ашиглах буюу хууль зөрчих замаар баян болох нь буруу зүйл биш.	49.5%	28.3%	16.1%	3.6%	2.5%	100.0%

UIH.MN
СУДАЛГААНЫ САН